



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2020.10.22 № 1/4328  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хоёрдогч зах зээлийн арилжааг  
эхлүүлэх тухай**


“Үндэсний хувьчлалын сан” хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл хүсэх тухай 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 12/20 тоот албан бичиг болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсан талаарх 2020 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 01/778 тоот албан бичигтэй тус тус танилцлаа.

Хорооны 2014 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 8.13-д “Хороо нэгж эрхийг анхдагч зах зээлд амжилттай болсонд тооцсон нөхцөлд тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлж болно” гэж заасан бөгөөд “Ард менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Үндэсний хувьчлалын сан” хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.9-д “Хороо хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулагдсанд тооцож хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноор сангийн үйл ажиллагаа эхлэх бөгөөд уг өдрөөс хөрөнгө оруулалтын менежментийн компани хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх нээгдэнэ” гэж заасныг анхаарна уу.

Хувийг: “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТХТ” ХХК, Голомт кастодиан банканд.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН